



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/01/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2020 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас:7058-4203, Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: Утас:7058-4204, Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 7058-4207, Цахим хаяг: Narmandakhd@audit.gov.mn Аудитор: Б.Одхүү Утас: 7058-4207, Цахим хаяг: Odkhuub@audit.gov.mn Аудитор: Ж.Баяртуул Утас:7058-4207, Цахим хаяг: Bayartuulj@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	3
2. Аудитын тайлан	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	6
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, АРГА зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө.....	7
2.8.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт	8
2.8.3 Авлага.....	8
2.8.4 Урьдчилгаа.....	9
2.8.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт	9
2.8.6 Бараа материал.....	9
2.8.7 Үндсэн хөрөнгө.....	10
2.8.8 Урт хугацаат хөрөнгө оруулалт	12
2.8.9 Өр төлбөр.....	12
2.8.9 Засгийн газрын хувь оролцоо	13
2.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	13
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	15
2.11. Шилэн дансны мэдээлэл.....	15
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	16
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	16
2.14. Аудитын зөвлөмж	16
3. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	17
3.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	17
3.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	19
3.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	22
3.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	25
3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	26
3.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	28
4.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	0



Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СС	Сангийн сайд
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
АЗДТГ	Аймгийн Засаг Даргын тамгын газар
ЗДТГ	Засаг Даргын тамгын газар
ЗДНС	Засаг Даргын нөөцийн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ААН	Аж ахуйн нэгж
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ДИС	Дорнод Их сургууль



Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1. Аудитын гэрчилгээ



**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

21000, Дорнод аймаг, Хүрэн сум 7-р баг
ЗДТТ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020-04-20 № 35 А

танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул "Зөрчилгүй" санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

011020312



Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дугаар зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2. Аудитын тайлан

2.1. Оршил

Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Засаг дарга М.Бадамсүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.



2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь үйл ажиллагаандаа “Мэргэшсэн, чадварлаг төрийн албан хаагчдыг тогтвортой ажиллуулж, орон нутгийн бодлого шийдвэрийг оновчтой төлөвлөн тасралтгүй сайжруулалтыг хийх замаар нутгийн захиргааны байгууллагуудыг үр дүнтэй удирдлагаар хангаж, иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ” гэсэн зорилтыг тавин ажилласан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд холбогдох хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулаагүй нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, санхүүгийн ажилтнуудад буруу мэдээлэл өгөх зэрэг үр дагавартай байна.

Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Дорнод аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газар, Төрийн сан, Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр 16 зөвлөмж өгсөн байна. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон ОНХС-гийн хөрөнгө оруулалтын 2019 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн явцад хяналт шалгалт хийсэн байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 14 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 14 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг нийт зардлаар сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг нийт зардлын 76,672.2 сая төгрөгийн 1 хувь буюу 766.7 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

2.8 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн

2.8.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 6,902.5 сая, эцсийн үлдэгдэл 8,148.3 сая төгрөг болж 1,245.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	10,8	10,9	+0.1
Банканд байгаа бэлэн мөнгө	6,391.7	7,637.4	+1,245.7
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	-	-
Хадгаламж	500,0	500,0	-
Дүн	6,902.5	8,148.3	+1245,8
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	1,103.9	2,128.8	+1,024.9
Төсөл/ сан	715.2	357.9	-357.3
Төрийн сан	2,983.4	3,221.2	+237.8
ТӨҮГ болон ОНӨҮГ	2,100.0	2,440.4	+340.4
Дүн	6,902.5	8,148.3	+1,245.8

Эх сурвалж: Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хадгаламж дансанд Дорнод Нийтийн Аж Ахуй ОНӨААТҮГ-ын 500.0 сая төгрөгийн хадгаламж байна.

Төрийн сангийн мөнгөн хөрөнгө

Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 2,983.4 сая, эцсийн үлдэгдэл 3,221.2 сая төгрөг болж, 237.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа мөнгөн хөрөнгө			
Төгрөг	2,983.4	3,221.2	+237.8
Төрийн сан	2,983.4	3,221.2	+237.8
Арилжааны банк	-	-	-
Гадаад валют			
Монголбанк	-	-	-
<i>Замд яваа хөрөнгө</i>			
Нийт дүн	2,983.4	3,221.2	+237.8

Эх сурвалж: Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төрийн сангийн эхний үлдэгдлээс тайлант онд 2,684.6 сая төгрөгийг орон нутгийн төсвийн зарлагыг санхүүжүүлэхэд, 298.8 сая төгрөгийг он дамжин хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд тус тус зарцуулсан байна.



Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тайлант онд орон нутгийн төсвийн орлогод 29,056.0 сая төгрөгийг бүрдүүлж, 26,371.4 сая төгрөгийг харьяа байгууллагуудын урсгал санхүүжилтэд, 2,684.6 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын санхүүжилтэд зарцуулжээ.

Аудитын илрүүлэлт:

- Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар Хэрлэн сумын ИТХ 6.0 сая төгрөг, Байгаль, орчин аялал жуулчлалын газар 8.7 сая төгрөг, нийт 14.7 сая төгрөгийн ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.
- Аймгийн Засаг дарга нь 2019 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн Б/64 тоот захирамжаар Засаг даргын нөөцийн сангаас 24 албан хаагчид цаг үеийн шинжтэй онцгой чухал даалгавар биелүүлсэн гэсэн үндэслэлээр 12.0 сая төгрөгийн урамшуулал олгосон ч тухайн албан хаагчдын ажлын үр дүн, гүйцэтгэлийг баталгаажуулж дүгнэсэн нотлох баримт хангалтгүй байна.
- Тайлант хугацаанд төрийн сангаар, төрийн сангийн мэргэжилтэн гарын үсэг зурж баталгаажуулаагүй 53,0 сая төгрөгийн 96 гүйлгээ, байгууллагын 1-р гарын үсэг зурагдаагүй 2.7 сая төгрөгийн 5 гүйлгээ, 2-р гарын үсэг зурагдаагүй 25,1 сая төгрөгийн 14 гүйлгээ тус тус хийгдсэн байна.
- Аймгийн ЗДНС-гаас 27,0 сая, сумдын ЗДНС-гаас 120.0 сая, нийт 147.0 сая төгрөгийг, уг журмын 2.1.6 дахь заалт дахь шагналыг урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламжид хамааруулан, тэмцээн уралдаан, баяр, ёслол, зөвлөгөөн, уулын тахилга, ахмадуудын хүлээн авалт зэрэг арга хэмжээнд хавтгайруулан зарцуулсан байна.
- Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам"-ын 2.4-д "энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь хэсэгт заасан хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээнд нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг зарцуулах ба хохиролд зарцуулагдаагүй үлдэгдлийг сарын хуваариас тооцоолж Засаг даргын нөөцөд бэлэн байршуулсан байна" гэж заасан ч бэлэн байршуулах үлдэгдлээс Баянтүмэн сум 12.7 хувь, Дашбалбар сум 21.0 хувь, Цагаан-Овоо сум 14.2 хувь, Хэрлэн сум 8.6 хувийг бусад зардалд зарцуулсан байна.

2.8.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансанд гүйлгээ хийгдээгүй ө байна.

2.8.3 Авлага

Авлага Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна—дансны эхний үлдэгдэл 3,920.2 сая, эцсийн үлдэгдэл 5,024.1 сая төгрөг болж, 1,103.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Авлагын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	13.5	5.7	-7.8
Төлбөртэй үйлчилгээний авлага	1.6	55.7	+54.1
Зээлийн хүүгийн авлага	0	16.9	+16.9
Дансны авлага /ТӨҮГ/	8.1	3.3	-4.8
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	0.3	0.1	-0.2
Бусад авлага	3,676.3	4,772.6	+1,096.3
Зээлийн авлага	220.4	169.8	-50.6
Дүн	3,920.2	5,024.1	1,103.9
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	2,488.4	3,359.7	+865.3
Төсөл/ сан	907.7	1,106.3	+198.6
Төрийн сан	123.9	117.9	-6.0
ТӨҮГ болон ОНӨҮГ	400.2	440.2	+40.0
Дүн	3,920.2	5,024.1	+1,103.9

Эх сурвалж: Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт авлагын эхний үлдэгдэл 3,920.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 5,018.1 сая төгрөгөөр тайлагнагдаж өмнөх онтой харьцуулахад 1,097.9 сая төгрөгөөр өссөн байна.

Нийт авлагын 32.0 хувь болох 1,605.8 сая төгрөг нь сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн он дамжсан хугацаа хэтэрсэн үлдэгдэл байгаа нь өмнөх оноос 118.1 сая төгрөгөөр өссөн байна.

Он дамжсан авлагын үлдэгдэл өндөр байгаа нь сангаас аж ахуй нэгж, иргэнд жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжихэд үзүүлэх зээл олголтын эх үүсвэр дутагдах, найдваргүй авлага үүсэх зэрэг сөрөг үр дагавартай байна.

Аудитын илрүүлэлт:

- СХС-ийн он дамжсан, хугацаа хэтэрсэн 1,605.8 сая төгрөгийн зээлийн авлага байна.
- Чулуунхороот сум нь СХС-гийн зээлийн хүүгийн авлагыг 3.3 сая төгрөгөөр илүү тооцон бүртгэснийг төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд залруулсан.
- Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь орон нутгийн төсвөөс авах техник хяналтын зардлын 55.4 сая төгрөгийг авлагаар бүртгээгүй байсныг ТШЗ-ийн тайланд залруулсан.

2.8.4 Урьдчилгаа

Урьдчилгаа ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.~~ дансанд гүйлгээ хийгдээгүй байна.

2.8.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.~~ дансанд гүйлгээ хийгдээгүй байна.

2.8.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.~~ эхний үлдэгдэл 7,390.8 сая, эцсийн үлдэгдэл 8,381.7 сая төгрөг болж, 990.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	573.0	703.0	+130.0
Эм боох материал	178.8	219.9	+41.1
Дуусаагүй үйлдвэрлэл	10.5	137.7	+127.2
Бэлэн бүтээгдэхүүн	7.0	10.2	+3.2
Бичиг хэргийн материал	219.6	242.0	+22.4
Аж ахуйн материал	2,326.2	2,541.8	+215.6
Сэлбэг хэрэгсэл	105.9	108.2	+2.3
Түлш, шатах тослох материал	69.8	65.5	-4.3
Барилгын засварын материал	14.4	16.4	+2.0
Хүнсний материал	6.5	14.4	+7.8
Бусад хангамжийн материал	2,233.8	2,653.0	+419.2
Мал амьтад	1,645.2	1,669.6	+24.4
Дүн	7,390.8	8,381.7	+990.9
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	7,121.6	8,010.0	+888.4
Төсөл/ сан	-	-	-
Төрийн сан	-	-	-
ТӨҮГ болон ОНӨҮГ	269.2	371.7	+102.5

Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дүн **7,390.8** **8,381.7** **+990.9**

Эх сурвалж: Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл өссөн нь байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай аж ахуйн материалыг худалдан авсантай холбоотой байна.

Бараа материалын үлдэгдэлд ашиглалтгүй, байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах боломжгүй бараа материал байхгүй байна.

Аудитын илрүүлэлт:

- ТЕЗ-ийн хамрах хүрээний аудитад хамрагдсан байгууллагуудаас 60,7 хувь нь худалдан авалтад е-баримтыг хавсаргаагүй, Хан-Уул цогцолбор сургууль нь 6,575.4 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн цахим төлбөрийн баримт дахь бараа материалын зориулалт нэр төрөл нь харилцахын болон няргын орлогын бүртгэл, гүйлгээнд хавсаргасан анхан шатны баримтаас зөрүүтэй, зориулалт бусаар зарцуулсанд төлбөрийн акт тогтоосон.
- ТЕЗ-ын хамрах хүрээний сургууль, цэцэрлэгүүдийн 36.5 хувь буюу 19 сургууль, цэцэрлэг нь хүүхдийн хоолны материал бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээг мөрдөж ажиллаагүй байгаа бөгөөд 214.0 сая төгрөгийн хүнсний материалын гэрээний үнээс илүү үнээр худалдан авсан байна.
- Сумдын эрүүл мэндийн төвүүд нь аймгийн ЭМГ-аар дамжин, төсөл хөтөлбөрүүдээр үнээгүй ирсэн 75.3 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг орлогод аваагүй байна.

2.8.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. эхний үлдэгдэл 172,575.6 сая, эцсийн үлдэгдэл 210,211.6 сая төгрөг болж, 37,636.0 сая төгрөгөөр өссөн байна.~~

Хүснэгт №5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл */сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж орон сууц	93,577.9	115,730.0	+22,152.1
Тээврийн хэрэгсэл	6,267.6	7,004.4	+736.8
Машин тоног төхөөрөмж	11,092.6	12,113.7	+1,021.1
Тавилга, эд хогшил	4,831.9	5,425.3	+593.4
Зам гүүрийн байгууламж	7,302.8	7,884.9	+582.1
Түүх соёлын дурсгалт зүйл	3,739.0	3,940.1	+201.1
Дуусаагүй барилга байгууламж	10,384.7	10,884.6	+499.9
Номын фонд	241.3	243.3	+2.0
Бусад үндсэн хөрөнгө	18,169.1	29,999.1	+11,830.0
Программ хангамж	441.0	451.3	+10.3
Биет бус хөрөнгө	16,527.7	16,534.9	+7.2
Дүн	172,575.6	210,211.6	+37,636.0
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	147,811.7	183,582.4	+35,770.7
Төсөл/ сан	-	-	-
Төрийн сан	-	-	-
ТӨҮГ болон ОНӨҮГ	24,763.9	26,629.2	+1,865.3
Дүн	172,575.6	210,211.6	+37,636.0

Эх сурвалж: Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 1,089.2 сая, балансаас баланст шилжүүлэн авсан 3,445.0 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 34,990.2 сая, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн авсан 11.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, шилжүүлсэн 751.2 сая, бусад 110.8 сая, акталсан 1037.7 сая төгрөгөөр хасагдсан байна.

Дуусаагүй барилга дансанд 10,884.6 сая төгрөгийн барилга байгууламж бүртгэгдсэн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- АЗДТГ-ын 5,198.7 сая төгрөгийн дуусаагүй барилгын санхүүжилт 2018, 2019 онуудын төсөвт тусгагдаагүйгээс зогсонги байдалтай байна.
- Спорт цогцолборын өргөтгөл, усан бассейн барилгын, усан сангийн цутгалтын ажил, гадна оруулга шугамын 395.0 сая төгрөгийн ажил хийгдэж 2012 оноос эхлэн санхүүжилт хийгдээгүй зогсонги байдалтай байна.
- Дашбалбар сумын Цэцэрлэгийн барилгын ажил 2019-2020 онуудад он дамжин хийгдэхээр төлөвлөгдсөн нь 2019 онд 353.2 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.
- Матад сумын Соёлын төвийн улсын төсвөөр хийгдэж байгаа эрх шилжээгүй барилгын ажил 2019 онд дуусахаар төлөвлөгдсөн ч бүрэн дуусаагүй, 300.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.
- Баян-Уул сумын улсын төсвөөр хийгдэж байгаа 2016 онд дуусах, эрх шилжээгүй "Шинэ сум төсөл"-ийн ажил 75% буюу 4,193.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.
- Баян-Уул сумын ЕБС-ын уурын зуухны ажил улс, орон нутгийн төсөв болон ОНХС гэсэн 3 эх үүсвэрээс санхүүжүүлж 2020 онд дуусахаар төлөвлөгдсөн нь 2019 онд 113,7 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.
- Чулуунхороот сумын макетын ажлын орон нутгийн төсвөөс он дамжуулан санхүүжүүлж, 2020 онд дуусахаар төлөвлөгдсөн нь 2019 онд 1.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.
- Чулуунхороот сумын ЕБС-ийн халаалтын тогооны ажлыг орон нутгийн төсвөөс он дамжуулан санхүүжүүлж, 2020 онд дуусахаар төлөвлөгдсөн нь 2019 онд 10.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.
- Чулуунхороот сумын Соёлын төвийн халаалт тогооны ажил орон нутгийн төсвөөс он дамжуулан санхүүжүүлж, 2020 онд дуусахаар төлөвлөгдсөн нь 2019 онд 5.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.
- Шинэ гудамж байгуулах ажлын гэрэлтүүлэг болон Найрамдал парсад байрлах эргийн хамгаалалтын байгууламж хийх нийт 314.3 сая төгрөгийн хөрөнгө "Гэрэл сэтгэмж" ОНӨҮГ-ын дуусаагүй барилгад бүртгэлтэй байна.

Орон нутгийн төсвөөр 2019 онд хийгдсэн 2,684.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлаас улсын комиссын актаар хүлээн аваагүй барилга, байгууламжийн дансанд шилжүүлээгүй барилга байгууламж байхгүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Сумдын төсөвт байгууллагуудад элэгдлээрээ зардлаа бүрэн нөхсөн ашигладаггүй 4,044.1 мянган төгрөгийн санхүүгийн болон архивын программ хангамж бүртгэлтэй байна.
- Халхгол сумын ЗДТГ-ын биет бус хөрөнгөнд 155,667.0 мянган төгрөгийн өртөгтэй цаашид ашиглагдахгүй болсон "сумын дэд бүтцийг сайжруулах, дулаан, цэвэр, бохир усны зураг төсөл" бүртгэлтэй байна.
- Матад сумын Соёлын төвд хуваарилагдсан 8.8 сая төгрөгийн хөгжим хэрэгсэл нь биет тооллогоор байгаагүй, улсын төсвийн байгууллага болох Хилийн 0306 дугаар ангид олгогдсон байна.
- Цагаан-Овоо сум нэмэлт санхүүжилтийн данснаас багаж тоног төхөөрөмж худалдан авахаар 5,160.0 мянган төгрөгийг шилжүүлж, хөрөнгийг хүлээн аваагүй байхад орлогоор бүртгэсэн байсныг тус тус санхүүгийн тайланд залруулсан.
- Чойбалсан сум ОНХС-гаас нийлүүлсэн 3,100.0 мянган төгрөгийн хүүхдийн тоглоомыг орлогод аваагүй, нэмэлт санхүүжилтийн данснаас багаж тоног төхөөрөмж худалдан авахаар 2,420.0 мянган төгрөгийг шилжүүлж, хөрөнгийг хүлээн аваагүй байхад орлогоор бүртгэсэн байсныг тус тус санхүүгийн тайланд залруулсан.



Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

- Чойбалсан сумын ЗДТГ нь жилийн эцсийн тооллого хийгээгүй санхүүгийн тайланг гаргасанд албан шаардлага өгч төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд залруулсан.

2.8.8 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалт дансанд гүйлгээ хийгдээгүй байна.

2.8.9 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн Монгол хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. Эхний үлдэгдэл 3,827.8 сая, эцсийн үлдэгдэл 4,055.4 сая төгрөг болж, 227.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Бүүрсан -
<i>Богино хугацаат өр төлбөр дүн</i>	416.6	644.2	+277.6
Ажиллагсадтай холбогдсон өглөг	20.5	3.7	-16.8
Бараа үйлчилгээний зардлын өглөг	29.2	4.2	-25.0
Бусад өглөг	366.9	618.1	+251.2
Барьцаа өглөг		18.2	+18.2
<i>Урт хугацаат өр төлбөр дүн</i>	3,411.2	3,411.2	-
Засгийн газрын байгууллага	3,411.2	3,411.2	-
Нийт дүн	3,827.8	4,055.4	+277.6
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	110.5	474.7	+364.2
Төсөл, сан	188.5	65.2	-123.3
Төрийн сан		0.6	+0.6
ТӨҮГ болон ОНӨҮГ	3,528.8	3,514.9	-13.9
ДҮН	3,827.8	4,055.4	+227.6

Эх сурвалж: Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрөөс 18.2 сая төгрөг нь барьцаа, 3.7 сая төгрөг нь ажиллагсадтай холбогдсон, 4.2 сая төгрөг нь бараа үйлчилгээний, 573.7 сая төгрөг нь байгууллагад төлөх, 6.9 сая төгрөг нь хувь хүнд төлөх, 26.1 сая төгрөг нь татварын, 11.4 сая төгрөг нь эмийн эргэлтийн сангийн дансны өр байна.

Барьцаа дансанд хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэлийн баталгаа 18.2 сая төгрөг байршуулсан байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл нь Дорнод Нийтийн Аж Ахуйн ОНӨААТҮГ-ын 2005 онд Азийн хөгжлийн банкнаас авсан урт хугацаат зээлийн 3,411.2 сая төгрөгийн өглөг байгаа бөгөөд анхны дүнгээс өөрчлөгдөөгүй байна.

Аудитын илрүүлэлт:

“Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйн хөгжлийн хоёрдугаар үе шатны МОН -1907 төсөл”-ийн гэрээнд аймгийн ЗДТГ нь Дорнод Нийтийн Аж Ахуй ОНӨААТҮГ-аас зээлийн хүүг жилд 2 удаа, үндсэн төлбөрийг 2010 оноос эхлэн авч, Сангийн яаманд төлөхөөр тусгаасан ч өнөөдрийг хүртэл хүү болон зээлийн эргэн төлөлт хийгдээгүй байна.

Нийт хүүгийн хуримтлагдсан өглөг болох 1,535.0 сая төгрөгийг Сангийн яамтай хийсэн тооцооны актад тусгаагүй байна. /Сангийн яамнаас хүүг хуримтлуулан бүртгэх талаар чиглэл өгч ажиллаагүй байгаа тул орон нутгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн алдаанаас хасаж, ЗГ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгуулах саналтай байна./



Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.8.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 161,190.7 сая, эцсийн үлдэгдэл 194,551.2 сая төгрөг болж, 33,360.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7 Засгийн газрын хувь оролцооны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/
Засгийн газрын сан	69,673.7	69,680.9	+7.2
Хуримтлагдсан үр дүн	50,667.0	84,029.1	+33,362.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	40,850.0	40,841.2	-8.8
Дүн	161,190.7	194,551.2	33,360.5
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	138,182.6	170,560.7	+32,378.1
Төсөл, сан	1,434.3	1405.0	-29.3
Төрийн сан	3,107.3	3,338.4	+231.1
ТӨҮГ болон ОНӨҮГ	18,466.5	19,247.1	+780.6
Дүн	161,190.7	194,551.2	33,360.5

Эх сурвалж: Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оруулсан капитал данс нэмэгдсэн нь биет бус хөрөнгө болох газар эзэмших эрхийг бүртгэсэнтэй холбоотой байна.

Бодлогын өөрчлөлт алдааны залруулгын дансанд бичилт хийгдсэн нь дахин үнэлгээтэй хөрөнгөнд хасагдуулаг хийгдсэнтэй холбоотой байна.

ТӨҮГ болон ОНӨҮГ-уудын хувьд эздийн өмч данс өссөн нь хөрөнгө оруулалтаас шалтгаалсан байна.

2.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 145 төсвийн байгууллага, 17 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 1 тусгай сан, 14 төвлөрүүлэн захирагч, нийт 177 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 165 байгууллага аудитад хамрагдаж, 10 байгууллагад итгэл үзүүлэн, 2 байгууллага аудитад хамрагдаагүй байна. “Наранбулаг хөгжил”, “Хулстай хөгжил” ОНӨААТҮГ-ууд тайланд онд үйл ажиллагаа явуулаагүй тул аудитад хамрагдаагүй болно.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 45 байгууллагыг түүвэрт хамруулж, 121 байгууллагад дүгнэлт хүргүүллээ. Үүнээс:

- Зөрчилгүй - 116,
- Хязгаарлалттай - 4 /аймгийн ЗДТГ, Чойбалсан сумын ЗДТГ, Матад сумын ЕБС, Гэрэл сэтгэмж ОНӨААТҮГ/,
- Санал дүгнэлтээс татгалзсан- 1 /Халхгол сумын 12 жилийн сургууль/

Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 13,637.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 2,463.9 сая төгрөгийн алдааг залруулж, 78.8 сая төгрөгийн зөрчилд 49 төлбөрийн акт тогтоож, 10,151.9 сая төгрөгийн зөрчилд 123 албан шаардлага, 57.7 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 4 санал хүргүүлж, 884.8 сая төгрөгийн алдаа, зөрчилд 125 зөвлөмж өглөө.

Formatted: Font: Arial, 10 pt, Font color: Auto

Formatted: Font: Arial, 10 pt, Font color: Auto

Formatted: Font: Arial, 10 pt, Font color: Auto



Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн албан шаардлага

1.СХС-гаас олгосон он дамжсан, хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдэл өмнөх оноос 118.1 сая төгрөгөөр өсөж 1,607.9 сая төгрөг болсон нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлэв.

2.Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах тухай захирамжуудад СС-ын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам”-ын заалтыг тусгаагүй байгаа бөгөөд аймгийн Засаг дарга нь 2019 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн Б/64 тоот захирамжаар Засаг даргын нөөцийн сангаас 24 албан хаагчид цаг үеийн шинжтэй онцгой чухал даалгавар биелүүлсэн гэсэн үндэслэлээр 12.0 сая төгрөгийн урамшуулал олгосон ч тухайн албан хаагчдын ажлын үр дүн, гүйцэтгэлийг баталгаажуулж дүгнэсэн нотлох баримт байхгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг зөрчиж санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлэв.

3.Дорнод их сургуулийн түшиц цэцэрлэг, лицей сургууль нь орон нутгийн төсвөөс санхүүжилт авдаг бөгөөд цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирлыг Дорнод их сургуулийн захирал томилсон нь Боловсролын тухай хуулийн 30.1.15 дахь Засаг даргын бүрэн эрхэд хамаарах “аймаг, ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийг томилох,” гэсэн заалтыг зөрчсөн байна. Мөн Дорнод Их сургууль, Дорнод лицей сургууль, Дорнод түшиц цэцэрлэг нь тус тусдаа улсын бүртгэлийн гэрчилгээтэй ТШЗ бүхий бие даасан 3 байгууллага боловч тус 3 байгууллагын төсвийг Дорнод Их сургуулийн захирал захиран зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 4.1.38 дахь “төсвийн шууд захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг” гэсэн заалтад нийцэхгүй байгаа бөгөөд орон нутгийн төсвөөс Түшиц цэцэрлэг нь 185.4 сая төгрөг, Лицей сургууль 87.0 сая төгрөгийн санхүүжилт авсан ч ТЕЗ-ийн тайланд нэгтгүүлсэн санхүүгийн тайлан дахь зарцуулалт нь Дорнод их сургуулийн зардалтай нийлсэн, анхан шатны баримтад үндэслээгүй байгаа нь Нягтлан бодон бүртгэлийн тухай хуулийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтад нийцэхгүй байна. Эдгээр нь санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ, хэмжилт, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлэв.

4.Тайлант хугацаанд төрийн сангийн мэргэжилтэн гарын үсэг зурж баталгаажуулаагүй 53,0 сая төгрөгийн 96 гүйлгээ, байгууллагын 1-р гарын үсэг зурагдаагүй 2.7 сая төгрөгийн 5 гүйлгээ, 2-р гарын үсэг зурагдаагүй 25,1 сая төгрөгийн 14 гүйлгээ хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг зөрчиж санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Хариуцлага тооцох санал хүргүүлэв.

5. НББББ-т тусгагдсан үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох талаарх заалтууд нь СС-ын 2018 оны 207 дугаар тушаалаар батлагдсан үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний талаарх аргачлалд заасан зарим заалтуудаас зөрүүтэй, бодлогын баримт бичгийн ашиглах нэмэлт материалын хэсэгт хүчингүй болсон ЗГ-ын тогтоол, СС-ын тушаал шийдвэрүүд байна. Энэ



Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

нь санхүүгийн тайлангийн үнэлгээ, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлэв.

Төсвийн ерөнхийлөн захирагчид 159.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 5 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Аудитаар нийт 999.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 718.5 сая төгрөгийн алдааг залруулж, 1.5 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 210.3 сая төгрөгийн зөрчилд 13 албан шаардлага, 1 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж, 69.1 сая төгрөгийн алдаа, зөрчилд 12 зөвлөмж өглөө.

Төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа төсвийн 145 байгууллагаас 10 байгууллагад итгэл үзүүлж, 45 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, Зөрчилгүй 86, Хязгаарлалттай 3 /аймгийн ЗДТГ, Чойбалсан сумын ЗДТГ, Матад сумын Ерөнхий боловсролын сургууль/, Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан 1 /Халхгол сумын 12 жилийн сургууль / дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 7,365.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,379.6 сая төгрөгийн алдааг залруулж, 76.0 сая төгрөгийн зөрчилд 43 төлбөрийн акт тогтоож, 5,366.0 сая төгрөгийн зөрчилд 96 албан шаардлага, 57.7 сая төгрөгийн алдаа, зөрчил гаргасан 2 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж, 486.0 сая төгрөгийн алдаа, зөрчилд 94 зөвлөмж өглөө.

Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа орон нутгийн өмчит 17 аж ахуйн нэгж байгууллагаас 1 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, Зөрчилгүй 13, Хязгаарлалттай 1 /Гэрэл сэтгэмж ОНӨААТҮГ/ дүгнэлт өгсөн. Наранбулаг, Хулстай хөгжил ОНӨААТҮГ-ууд нь үйл ажиллагаа явуулаагүй “Х” тайлан ирүүлсэн тул аудит хийгдээгүй.

Аудитаар нийт 4,393.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 79.8 сая төгрөгийн алдааг залруулж, 1.3 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 4,157.7 сая төгрөгийн зөрчилд 9 албан шаардлага, 154.6 сая төгрөгийн алдаа, зөрчилд 12 зөвлөмж өглөө.

Тусгай санд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар

Мал хамгаалах санд “Зөрчилгүй” санал дүгнэлт өгч аудитаар нийт 30.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 15.4 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 15.4 сая төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өглөө.

2.10. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Азийн хөгжлийн банкнаас авсан 3,411.2 сая төгрөгийн урт хугацаат зээлийн хүүгийн төлбөрийг тооцож бүртгэх талаар Сангийн яамнаас чиглэл ирүүлсэн эсэх, хүүгийн хуримтлагдсан өглөгийг Сангийн яамтай хийсэн тооцооны актад тусгасан эсэх талаар дараагийн аудитад анхаарах шаардлагатай.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу 23175 мэдээлэл байршуулснаас 20556 мэдээллийг хугацаанд



Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

нь, 2619 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Мэдээллийг бүрэн байршуулсан эсэхийг нэгдсэн удирдамжаар хийгдэж байгаа нийцлийн аудитаар шалгаж байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид өгсөн 3.4 тэрбум төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлж, хэрэгжилт 100 хувьтай байна.

2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Залруулагдаагүй 562.2 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 766.7 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага тул “Зөрчилгүй” дүгнэлтийг өгч байна.

Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

[Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.](#)

2.14. Аудитын зөвлөмж

1. Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь улсын төсвийн байгууллагуудын ТШЗ-дад урамшуулал олгохоор шийдвэрлэсэн нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 1.2.1 дэх “төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид” гэсэн заалтыг мөрдөж ажиллах.
2. ТЕЗ-ийн хамрах хүрээний байгууллагуудаас 60,7 хувь нь худалдан авалтын е-баримтыг хавсаргаагүй байна. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэсэн заалтад нийцэхгүй байна. Иймд ААН, байгууллагуудыг худалдан авалт болон ажил гүйлгээ гүйцэтгэхдээ анхан шатны Е-баримтыг бүрэн бүртгэж, баталгаажуулж байх чиглэлийг Татварын хэлтэст хүргүүлж ажиллах.
3. ЗДНС-гийн хөрөнгийг тэмцээн уралдаан, баяр, ёслол, зөвлөгөөн, уулын тахилга, ахмадуудын хүлээн авалт зэрэг арга хэмжээнд зарцуулахгүй байх.
4. Сангийн Сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам”-ын 2.4 дэх хэсэгт “энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь хэсэгт заасан хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээнд нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг зарцуулах ба хохиролд зарцуулагдаагүй үлдэгдлийг сарын хуваариас тооцоолж Засаг даргын нөөцөд бэлэн байршуулсан байна” гэж заасныг баримтлан ажиллах.



Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5. Элэгдлээрээ зардлаа бүрэн нөхсөн ашиглалтгүй байгаа 4,044.1 мянган төгрөгийн программ хангамж болон Халхгол сумын ЗДТГ-ын биет бус хөрөнгөнд бүртгэлтэй 155,667.0 мянган төгрөгийн өртөгтэй “сумын дэд бүтцийг сайжруулах, дулаан, цэвэр, бохир усны зураг төсөл”-ийг ашиглалтад оруулах талаар судалж, асуудлыг шийдвэрлэх.

3. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

3.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

